



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А06

Улаанбаатар хот

“Улаанбаатар өвлийн явган алхалт” арга
хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, “Аялал жуулчлалын арга хэмжээ” зохион байгуулах тухай нийслэлийн Засаг даргын 2024 оны А/175 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 захирамжаар баталсан Газрын дүрмийн 4.1.8 дахь заалт, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Улаанбаатар хотод өвлийн улиралд зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатар өвлийн явган алхалт”-ийг 2024 оны 03 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд тогтсон маршрутын дагуу зохион байгуулсугай.

2.Арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 14.550.000 (арван дөрвөн сая таван зуун тавин мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

4.Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 02 сарын 06 өдрийн
A06 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



УДИРДАМЖ

2024 оны 02 дугаар сарын 05

Улаанбаатар хот

“Улаанбаатар өвлийн явган алхалт” арга хэмжээг зохион байгуулах тухай
Зорилго:

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил”
болгон зарласантай холбогдуулан өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх,
Улаанбаатар хотод зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор
“Улаанбаатар өвлийн явган алхалт”-ын арга хэмжээг зохион байгуулна.

Хугацаа, хамрах хүрээ:

Улаанбаатар өвлийн явган алхалтад гадаад, дотоодын жуулчид,
нийслэлийн иргэдийг хамруулж 2024 оны 03 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд

Ерөнхий зохион байгуулагч:

- Нийслэлийн Аялал жуулчлалын газар
- Монголын явган алхалтын холбоо ТББ

Хамтран зохион байгуулагч:

- Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ
- Скай резорт цанын бааз
- Олон улсын хүүхдийн Найрамдал төв

Дэмжигч байгууллага:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Арга хэмжээний хөтөлбөр:

2024.03.02 Бямба гариг

Нийт алхах зай 10км

10:00-10:30 Нээлтийн үйл ажиллагаа / Урлагийн тоглолт, бие халаалт, бүртгэлийн
дугаар, Старт тамга даруулах/

12:00-13:00 Туул өртөө, Цаатны отог / Мөсөн шагайн тэмцээн, уралдаан, өдрийн
хоол, амралт/

14:30-15:00 Мөсөн хотхоны өртөө / Скай резорт, хаалтийн үйл ажиллагаа,
төгсгөлийн тамга даруулах/

2024.03.03 Ням гариг

Нийт алхах зай 10км

09:30-10:00 Жанжин Д.Сүхбаатарын талбайгаас автобусанд сууж Найрамдал зусланруу хөдлөнө.

11:00-11:30 Нээлтийн үйл ажиллагаа / Урлагийн тоглолт, бие халаалт, бүртгэлийн дугаар, Старт тамга даруулах/

11:30-13:30 Жавхлантай өртөө / Өртөөтэй танилцаж амрах/

13:30-14:30 Өдрийн хоол

14:30-15:00 Хараацай театр /Хаалтын үйл ажиллагаа, Амжилтын сертификат гардуулах/

15:00-15:10 Автобусанд сууж Жанжин Д.Сүхбаатарын талбайруу хөдлөх

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 02 сарын 26 өдрийн
1106 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“УЛААНБААТАР ӨВЛИЙН ЯВГАН АЛХАЛТ” АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨСВИЙН ЗАДАРГАА

2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр
хот

Улаанбаатар

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз хөгжим түрээс ажил	Багц	4,000,000	4,000,000
2	Анонс хэвлэл (тайзны, өртөөний, чиглэл заасан, автобусны)	Багц	1,000,000	1,000,000
3	Автобусны зардал	6*1өдөр	700,000	4,200,000
4	Урлагийн тоглолт зохион байгуулах	Багц	2,000,000	2,000,000
5	Оролцогчдын сертификат (Алхалтын батламж)	500ш	2,000	1,000,000
6	Оролцогчдын энгэрийн тэмдэг	500ш	1,500	750,000
7	Оролцогчдын гараа, өртөө, бариа тэмдэглэх хуудас	1000ш	600	600,000
8	Тэмцээн уралдааны шагнал	Багц	1,000,000	1,000,000
10	Нийт дүн:			14,550,000.00